



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/29

Бодь

Г Шар усны үерээс урьдчилан Г
сэргийлэх чиглэлээр авах зарим арга
хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/188 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цаг агаарын дулааралтай холбогдуулан цас ихтэй уулархаг газар, гуу, жалга, гол, мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасаж шар усны үеэр буух аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан гаргаж, ард иргэдэд шуурхай хүргэх, болзошгүй эрсдэлийн судалгааг гаргаж сумын Онцгой комисст танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Цаг уурын харуул (Т.Төмөрсүх)-д,

3.Дээрх өдрүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зам тээврийн хөдөлгөөнд хяналт тавьж аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (М.Цэнд-Аюуш)-д,


4.Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдийг гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээг тогтмол хүргэж эрсдэл бүхий газруудад самбар байршуулж ажиллахыг Шуурхай штабын ахлах (Н.Сумъяа)-т,

5.Гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагууд болон уулын ам, бэл, гуу, жалга, сувгийн ойролцоо айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бууж суурьшихгүй байхыг анхааруулах, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийн судалгааг гаргаж, мэдэгдэл хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА

Р.БАТЖАРГАЛ



642201037